

**2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 01 сарын 11-ний өдрийн 17.00 цагаас өмнө файл болон цаасан хэлбэрээр баталгаажуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ЕРП Б.Одбаяр)-т ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагынхаа гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс удаашралтай байгаа заалтуудыг төлөвлөгөөнд тусган батлуулах /Төсвийн бус хөрөнгөөр хийх боломжтой ажил, эх үүсвэрүүдийг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тодорхой тусгах/	ТЗУХ ААНБ
2.	Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримтлах Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, дүүрэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	ЗДО Б.Болормаа
3.	Дотоодын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймаг, 9 дүүргийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулан үндэсний бараа, бүтээгдэхүүнээр “Сар шинийн өргөтгөсөн үзэсгэлэн, арга хэмжээ”-г зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллах.	ТХҮХ ЖДҮҮДТ
4.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулж, байгууллагын үргүй зардлыг багасгаж, нийслэлийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, дотоод хяналт шалгалтаа сайжруулж, үр дүнг шаардаж ажиллах	СТСХ Татварын хэлтэс ААНБ
5.	Нийтийн эзэмшлийн гудамж, орон сууц, гэр хорооллын гудамж дундах явган хүний зам болон аж ахуй нэгж байгууллагуудын ойр орчмын талбайн цас, мөс цэвэрлэх ажлаа эрчимжүүлэх	ТХҮХ Багахангай тохижилт ОНӨААТҮГ ААНБ
6.	Орон сууцны хороолол болон гэр хорооллын хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шаардлагатай хүн хүч, машин, тоног төхөөрөмжөө нэмэгдүүлж ажиллах.	ТХҮХ Багахангай тохижилт ОНӨААТҮГ

7.	Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, дунд болон богино хугацааны сургалтад хамруулах, чадавхжуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	ЗДТГ
8.	Нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагч, удирдах албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг өндөржүүлж, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	ЗДТГ ААНБ
9.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч болон удирдлагад хариуцлага тооцож ажиллах.	ТЗУХ ААНБ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10.	Хил залгаа нутаг дэвсгэрт бог малын мялзан өвчний тохиолдол илэрсэнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, малчдад мэдээллэх	ТХҮХ ХААТ Мал эмнэлгийн тасаг Хороод
11.	Өвөлжилтийг даван туулахад шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж, ОУ-ын байгууллагуудаас /МУЗН/ тусламж туслалцаа хүсэх	ЗД-ын зөвлөх ТХҮХ ААНБ
12.	Авто зам болон явган хүний замын цасыг цэвэрлэж, зорчих хэсгийг бүрэн нээх, ажилтан албан хаагчдын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийж, албан хаагчдын бүтцэд өөрчлөлт хийх саналаа танилцуулах	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
13.	Дүүрэгт мал аж ахуй эрхлэх бүс, хориглох бүсийг тогтоохтой холбоотой санал боловсруулж, танилцуулах	ТХҮХ Хороод
14.	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн мод, бутны бүрэн бүтэн байдал, арчлалт хамгаалалтыг сайжруулах	Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ
15.	Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй газар эзэмшигчдийн мэдээллийг нэгтгэн танилцуулж, хариуцлага тооцон газар эзэмших эрхийг цуцлах хүртэлх арга хэмжээг авч ажиллах /энэ 7 хоногт багтаан танилцуулах/	ГЗБА
16.	“Трансгайд” ХХК-ий үйл ажиллагаатай холбоотой албан бичиг төлөвлөн хүргүүлэх, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах	ТХҮХ
17.	ААНБ-ууд гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх	ТХҮХ Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ ААНБ
18.	Стандартын шаардлага хангасан хаягжуулалт болон камержуулалтын тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	ТХҮХ Багахангай гэрэлтүүлэг

		ногоон байгууламж ОНӨААТҮГ ААНБ
19.	ААНБ-ууд ажлын байрны шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүрийн 25-ны өдрийн дотор ХХҮХ-т хүргүүлж байх	ХХҮХ ААНБ
20.	Суурьшлын бүс болон зорилтот бүлгийн айл өрхүүдийн гудамж, зам талбайн цасыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, саадгүй зорчих боломжийг бий болгох	ЗД-ын зөвлөх ОНӨААТҮГ-ууд
21.	Нийслэлээс эрх шилжиж ирэх ажил, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын техникийн тодорхойлолтыг боловсруулж, үнэлгээний хороог 2023 оны 1 дүгээр сард багтаан байгуулах	ЗДО Б.Болормаа СТСХ ХААА